# : Зөрчилдөөнийг хэрхэн даван туулж үр дүнд хүрэх вэ?

Хамрах хүрээ: 9 анги

# Өмнөх хичээл бататгах асуулт:

- Харилцаа гэж юу вэ?
- Бид хэрхэн харилцан үйлддэг вэ?
- Харилцан үйлдлийн хэлбэрүүдийг нэрлэнэ үү.
- Бусадтай хэрхэн үр дүнтэй харилцах вэ?

# Харилцан үйлдлийн хэлбэрүүдийг нэрлэнэ үү.

- ✓Солилцоо
- ✓Өрсөлдөөн
- ✓Хамтын ажиллагаа
- ✓Зөрчилдөөн
- ✓Албадлага

# Зөрчилдөөн гэж юу вэ?

Зөрчилдөөн бол хоорондоо нийцэхгүй, эсрэг тэсрэг хэрэгцээ тэмүүлэл, хүсэл эсвэл шаардлагаас үүдэх сөргөлдөөн юм.




Хүмүүс хоорондын харилцааны явцад зөрчил маргаан үүсдэг.

# Зөрчилдөгч талууд

- Хувь хүний дотоод зөрчил
- Хүмүүс хоорондын
- Бүлэг хоорондын
- Хувь хүн ба бүлгийн

# Зөрчилдөөний өдөөгч

- Шаардлага
- Бухимдал
- Шүүмжлэл
- Үгүйсгэл

# Зөрчилдөөн үүсэх шалтгаан

- Үзэл бодлын
- Үүргийн
- Үл ойлголцлын
- Зорилгын
- Ашиг сонирхлын
- Үнэлэмжийн
- Хуваарилалтын

# Зөрчилдөөний үе шатууд

- Далд үе: Зөрчилдөөн байгааг мэдээгүй үе
- Хүлээн авах үе: Зөрчилдөөн байгаа мэдэх үе
- Мэдрэх үе: Стресс сэтгэл зовнил
- Оргил үе: Зөрчилдөөн ил тод өрнөх үе
- Дараах үе: Зөрчилдөөний үр дүн шийдэл ба мухардал

# Тохиолдол шинжлээрэй.

| Тохиолдол | Өдөөгч | Зайлсхийх хувилбар |
|---|---|---|
| Б-г ажлаа тараад оройхон гэртээ иртэл эхнэр нь хаалга тайлж өгөөд “Чи оройтож ирэхээ утсаар хэлэхгүй яасан юм бэ?”гэж хэлэв. “Ажилтай байхад би яах юм гэж Б ширүүн хариулав. | | |
| | | |
| | | |

Хуудас 17 үргэлжлүүлэн хийх

# Хүмүүс зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлага

- Зайлсхийх: зөрчилдөөний гадуур үлдэх хэлэлцэн зөвшилцөхийг үл ойшоох, эсвэл төвийг сахисан байр суурийг барих хандлага юм.
- Сөргөлдөх: Ийм хандлагатай хүн бусдын санал бодлыг үл ойшоож, зөвхөн өөрийн зорилгыг биелүүлэхийг бүрэн хичээдэг. Эрх мэдлээр далайлга, захиран тушаах өнгө аяс илэрдэг.

# Хүмүүс зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлага

- Буулт хийх: энэ нь бусадтай хамтрах хүсэл сонирхолтой боловч дайчин шаргуу бус зан төлвөөр илэрдэг. Зөрчилдөөнтэй байдалд тодорхой асуудал дээр өөрийн итгэл үнэмшил байр сууринаасаа ухрах, ухрах татгалзах замаар асуудлыг шйидвэрлэдэг.
- Хамтран ажиллах: аль аль талдаа үр ашигтай буюу ЯЛНА-ЯЛНА гэдэг зарчмыг баримтлах байдлаар илэрдэг.
- Харилцан буулт хийх буюу дундын шийдэл: Харилцан үр ашигтай шийдлийг хэлэлцэн тохиролцох эрмэлзлэл юм.


Зүтгэлтэй
Сөргөлдөх
(давуу тал олох ноёрхох)
Хамтран ажиллах
(Зэрэгцэн орших)
Хамтрах
сонирхол
бага
Харилцан буулт
хийх
Хамтрах
сонирхол
их
Зайлсхийх
(Үгүйсгэх арга)
Буулт хийх
(найр тавих)
Зүтгэлгүй

- Зөрчилдөөн үүсвэл сөрөг үр дагавар гарахаас өмнө түүнийг шийдвэрлэх чадварт суралцах хэрэгтэй.

Гэрийн даалгаварт: хуудас 19 “ гэртээ хийгээрэй”хийх:
Зөрчилдөөнөөс сэргийлэх арга замуудыг нэрлээрэй.